ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2024/257/НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭСАНТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер: О.Амаржаргал

Утас: 70273463. Цахим хаяг:amarjargal@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК Гүйцэтгэх захирал: С.Оюунгэрэл

Утас: 99170900 Цахим хаяг:info@goldenpageaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open audit.mn

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт ....................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга....................
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ....................
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ....................
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....................
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ....................
4. Аудитын тайлан....................
   4.1 Ерөнхий зүйл ....................
   4.2 Материаллаг байдал ....................
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт....................
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..........
   4.5 Засврын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....................
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....................
5. Аудитын илрүүлэлт ....................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТОУС | Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/86.

танай ______ -ны № ______ -т

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭСАНТ
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ц.ЦЭВЭЭНСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэсант сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэсант сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх болсноор жилийн эцэст зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийг дараагийн жилд зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 68,119.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

0190?0100

**Бусад асуудлын хэсэг**

Эрдэнэсант сумын хүүхдийн цэцэрлэг "Сургуулийн өмнөх боловсролыг хүүхдийн төлөвшил, хөгжлийн суурь үе хэмээн үзэж, цэцэрлэгийн үйлчилгээний болон сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг зохион байгуулна" гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Төв аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93,8 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **55,132,520.05** | **108,957,587.69** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **21,174,049.25** | **68,119,673.89** |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 21,174,049.25 | 68,119,673.89 |
| 3121 | Төгрөг | 21,174,049.25 | 68,119,673.89 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 21,174,049.25 | 68,119,673.89 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 33,958,470.80 | 40,837,913.80 |
| 351 | Түүхий эд материал | 33,151,720.80 | 38,932,663.80 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 33,151,720.80 | 38,932,663.80 |
| 354 | Хангамжийн материал | 806,750.00 | 1,905,250.00 |
| 35460 | Хүнсний материал | 556,750.00 | 1,655,250.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 250,000.00 | 250,000.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,291,757,944.36** | **224,790,782.78** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,291,757,944.36** | **224,790,782.78** |
| 392 | Биет хөрөнгө | 1,289,355,944.36 | 222,388,782.78 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,232,424,463.00 | 187,254,344.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -39,411,490.20 | (26,467,048.44) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 63,960,455.00 | 52,183,980.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -12,641,753.06 | (14,033,358.01) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 57,266,256.66 | 39,512,851.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -14,125,937.04 | (17,945,935.77) |
| 39217 | Ном | 1,883,950.00 | 1,883,950.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 2,402,000.00 | 2,402,000.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -550,000.00 | (550,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,402,000.00 | 2,402,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,346,890,464.41** | **333,748,370.47** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,346,890,464.41** | **333,748,370.47** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,346,890,464.41 | 333,748,370.47 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 177,577,148.00 | 177,577,148.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 177,577,148.00 | 177,577,148.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,098,124,030.00 | 84,981,936.06 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,098,124,030.00 | 1,098,124,030.00 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | (1,013,142,093.94) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 71,189,286.41 | 71,189,286.41 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,346,890,464.41** | **333,748,370.47** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,899,012,567.08 | 600,556,737.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,888,431,767.08 | 600,556,737.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,367,287,367.08 | 14,858,237.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,332,494,756.28 | 14,858,237.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,514,623.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,329,980,133.28 | 14,858,237.00 |
| 120008 | Орон нутгийн төсвөөс | 34,792,610.80 | 00.00 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 521,144,400.00 | 585,698,500.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 409,217,300.00 | 536,201,200.00 |
| 123004 | Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг | 111,927,100.00 | 49,497,300.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 10,580,800.00 | 00.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 10,580,800.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,580,800.00 | 00.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 552,122,102.67 | 558,292,478.65 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 552,122,102.67 | 558,292,478.65 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 529,089,135.38 | 547,743,054.87 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 308,186,304.37 | 344,695,263.78 |
| 210101 | Үндсэн цалин | 223,840,305.57 | 236,666,762.25 |
| 210102 | Нэмэгдэл | 72,769,046.70 | 91,065,618.91 |
| 210104 | Урамшуулал | 11,576,952.10 | 16,962,882.62 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 36,317,428.09 | 39,127,127.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,278,698.63 | 28,701,120.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,526,453.79 | 1,598,971.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,416,279.87 | 2,349,843.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 459,029.05 | 195,578.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,636,966.75 | 6,281,615.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 70,261,181.00 | 45,954,783.80 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,883,481.00 | 14,846,696.30 |
| 210302 | Түлш, халаалт | 53,677,700.00 | 29,808,087.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,700,000.00 | 1,300,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 00.00 | 4,043,330.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 4,043,330.00 |
| 2105 | Нормативт зардал | 56,650,215.00 | 69,632,750.00 |
| 210502 | Хоол, хүнс | 56,650,215.00 | 69,632,750.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 750,000.00 | 564,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 750,000.00 | 564,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,043,000.00 | 1,189,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 19,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,043,000.00 | 1,170,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 55,881,006.92 | 42,536,800.29 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,615,885.00 | 11,515,135.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,892,433.00 | 3,205,442.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 39,372,688.92 | 27,816,223.29 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 23,032,967.29 | 10,549,423.78 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 14,913,400.00 | 7,506,907.58 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 10,373,800.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,539,600.00 | 7,506,907.58 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 8,119,567.29 | 3,042,516.20 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,119,567.29 | 3,042,516.20 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 1,346,890,464.41 | 42,264,258.35 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 00.00 | 1,055,406,352.29 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 1,048,789,318.71 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 6,617,033.58 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | 00.00 | (1,055,406,352.29) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 1,346,890,464.41 | (1,013,142,093.94) |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **534,239,823.00** | **585,698,500.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **523,659,023.00** | **585,698,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,514,623.00 | 00.00 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 2,514,623.00 | 00.00 |
| **1200041** | **Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих** | 2,514,623.00 | 00.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 521,144,400.00 | 585,698,500.00 |
| **123001** | **Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого** | 409,217,300.00 | 536,201,200.00 |
| **123004** | **Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг** | 111,927,100.00 | 49,497,300.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 10,580,800.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 10,580,800.00 | 00.00 |
| **131104** | **Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө** | 10,580,800.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **513,065,773.75** | **538,752,875.36** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **513,065,773.75** | **538,752,875.36** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 490,032,806.46 | 528,203,451.58 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 308,186,304.37 | 344,473,263.78 |
| **210101** | **Үндсэн цалин** | 223,840,305.57 | 236,382,010.17 |
| **210102** | **Нэмэгдэл** | 72,769,046.70 | 91,067,741.12 |
| **210104** | **Урамшуулал** | 11,576,952.10 | 17,023,512.49 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,317,428.09 | 39,349,127.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,278,698.63 | 28,473,014.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,526,453.79 | 1,598,971.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,416,279.87 | 2,349,843.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 459,029.05 | 195,578.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,636,966.75 | 6,731,721.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 70,261,181.00 | 45,954,783.80 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,215,281.00 | 4,910,638.30 |
| 210302 | Түлш, халаалт | 61,345,900.00 | 39,744,145.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,700,000.00 | 1,300,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 54,632,675.00 | 69,754,850.00 |
| 210502 | Хоол, хүнс | 54,632,675.00 | 69,754,850.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 750,000.00 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 750,000.00 | 500,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 962,000.00 | 1,154,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 962,000.00 | 1,154,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,923,218.00 | 27,016,527.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,601,500.00 | 23,551,727.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,321,718.00 | 3,464,800.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 23,032,967.29 | 10,549,423.78 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 14,913,400.00 | 7,506,907.58 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 10,373,800.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,539,600.00 | 7,506,907.58 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 8,119,567.29 | 3,042,516.20 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,119,567.29 | 3,042,516.20 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 21,174,049.25 | 46,945,624.64 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 21,174,049.25 | 46,945,624.64 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **00.00** | **21,174,049.25** |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **21,174,049.25** | **68,119,673.89** |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 175,175,148.00 | 124,514,964.92 | (26,445,571.18) | 273,244,541.74 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **175,175,148.00** | **124,514,964.92** | **(26,445,571.18)** | 273,244,541.74 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 12,718,372.79 | 12,718,372.79 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **177,577,148.00** | **71,189,286.41** | **1,098,124,030.00** | 1,346,890,464.41 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **177,577,148.00** | **71,189,286.41** | **1,098,124,030.00** | 1,346,890,464.41 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -1,013,142,093.94 | -1,013,142,093.94 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **177,577,148.00** | **71,189,286.41** | **84,981,936.06** | 333,748,370.47 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **606,866,900.00** | **512,670,432.16** | **(94,196,467.84)** | **84.50%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **606,866,900.00** | **512,670,432.16** | **(94,196,467.84)** | **84.50%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **599,359,900.00** | **505,163,524.58** | **(94,196,375.42)** | **84.30%** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 393,760,600.00 | 344,473,263.78 | (49,287,336.22) | 87.50% |
| 210101 | Үндсэн цалин | 261,891,900.00 | 236,382,010.17 | (25,509,889.83) | 90.30% |
| 210102 | Нэмэгдэл | 117,190,900.00 | 91,067,741.12 | (26,123,158.88) | 77.70% |
| 210104 | Урамшуулал | 14,677,800.00 | 17,023,512.49 | 2,345,712.49 | 116.00% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 49,216,200.00 | 39,349,127.00 | **(9,867,073.00)** | 80.00% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,467,000.00 | 28,473,014.00 | (4,993,986.00) | 85.10% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,937,600.00 | 1,598,971.00 | (2,338,629.00) | 40.60% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,149,500.00 | 2,349,843.00 | (799,657.00) | 74.60% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 787,500.00 | 195,578.00 | (591,922.00) | 24.80% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,874,600.00 | 6,731,721.00 | (1,142,879.00) | 85.50% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 48,997,300.00 | 45,954,783.80 | **(3,042,516.20)** | 93.80% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,953,100.00 | 4,910,638.30 | (3,042,461.70) | 61.70% |
| 210302 | Түлш, халаалт | 39,744,200.00 | 39,744,145.50 | (54.50) | 100.00% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,300,000.00 | 1,300,000.00 | 0.00 | 100.00% |
| **2105** | **Норматив зардал** | 78,689,800.00 | 69,754,850.00 | **(8,934,950.00)** | 88.60% |
| 210502 | Хоол, хүнс | 78,689,800.00 | 69,754,850.00 | (8,934,950.00) | 88.60% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 500,000.00 | 500,000.00 | 0.00 | 100.00% |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 500,000.00 | 0.00 | 100.00% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,154,900.00 | 1,154,900.00 | 0.00 | 100.00% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,154,900.00 | 1,154,900.00 | 0.00 | 100.00% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 27041100 | 3976600 | **(23,064,500.00)** | 14.70% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,576,300.00 | 511,800.00 | (23,064,500.00) | 2.20% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,464,800.00 | 3,464,800.00 | 0.00 | 100.00% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7507000 | 7506907.58 | -92.42 | 100.00% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,507,000.00 | 7,506,907.58 | (92.42) | 100.00% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,507,000.00 | 7,506,907.58 | (92.42) | 100.00% |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0 | 21,174,049.25 | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0 | 68,119,673.89 | | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус цэцэрлэг нь анх Улаанхудаг гэдэг газар 1961 онд 4 орон тоотойгоор 25 хүүхэдтэй төрийн өмчид тулгуурлан байгуулагдсан. 1969 онд 50 хүүхдийн хүчин чадалтайгаар одоогийн цэцэрлэгийн байр ашиглалтад оржээ.

2023 онд 1 эрхлэгч, 6 багш, 6 туслах багш үйлчилгээний 7 ажилтан нийт 20 бүтэц оронтой, 125 хүүхдийн хүчин чадалтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Манай байгууллагын онцлог чухал ажлууд :

- Цагаан идээ-хүнсний ногоо: Жил бүр "Алтан намар-Амтат хоол өдөрлөг уламжлал болгон зохион байгуулдаг
- Эсгий урлал:Сургалтын орчныг тохижуулах, сургалтын хэрэглэгдэхүүн хийх
- Бүтээлийн үзэсгэлэн: Багш нарын бага хурал" Хүүхэд бүр цэцэрлэгт хөтөлбөрийн тайлан, бусийн үйл ажиллагаанд тогтмол оролцож туршлага түгээн дэлгэрүүлж хэвшсэн.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Эрдэнэсант сумын хүүхдийн цэцэрлэг нь Боловсрол шинжлэх ухааны ерөнхий газрын харьяа сургуулийн өмнөх боловсрол олгох байгууллага юм.

Эрдэнэсант сумын хүүхдийн цэцэрлэг нь Төв аймгийн Засаг даргын 2013 оны 10 дугээр сарын 11-ний өдрийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн 0000955 тоот гэрчилгээтэй. Сургалт эрхлэх хугацааг 2028 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл сунгасан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд доорх өөрчлөлт орсон.Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Боловсролын ерөнхий хууль
- Сургуулийн өмнөх болон боловсролын тухай хууль
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
- Зөвшөөрлийн тухай хууль
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалт
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Төрийн цалингийн доод хэмжээг тогтоосон.

Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтад өөрчлөлт орсон.

**Бусад асуудлын хэсэг**

- Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, үнэлгээ арга зүй, технологи, суралцагчийн эрх, хамгаалал, хөгжил, төлөвшил, тэгш хамран сургалт, ажил

мэргэжлийн баримжаа, багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжил, удирдах ажилтныг мэргэжил арга зүйгээр хангах, зөвлөн туслах олон нийтийг энэ чиглэлийн мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлж ажиллах, холбогдох талуудын түншлэлийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөн гүйцэтгэлийг ханган ажиллалаа

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглахгүй шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Эрдэнэсант сумын хүүхдийн цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дугаар сарын 24-ны өдрийн А/02 дугаар тушаалаар батлагдсан Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллагуудад мөрдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" байна.

Төв аймгийн Эрдэнэсант сумын хүүхдийн цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Эрдэнэсант сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн бөгөөд тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,013,142.1 мянган төгрөгөөр буюу 75,2 хувиар *буурсан* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 21,174.1 | 68,119.7 | 46,945.6 |
| Бараа материал | 33,958.5 | 40,837.9 | 6,879.4 |
| Үндсэн хөрөнгө | 1,291,757.9 | 224,790.8 | 1,066,967.1 |
| **Нийт хөрөнгө** | **1,346,890.5** | **333,748.4** | **1,013,142.1** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 177,577.2 | 177,577.2 | |
| Хуримтлагдсан үр дүн | 1,098,124.0 | 84,981.9 | 1,013,142.1 |
| Хөрөнгийн үнэлгээний зөрүү | 71,189.3 | 71,189.3 | |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,346,890.5** | **333,748.4** | **1,013,142.1** |

Хүснэгтээс харахад 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна.

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 46,945.6 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 6,879.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 89,034.6 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 8,776.2 мянган төгрөг нийт 97,810.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 80,764.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 1,013,142.1 мянган төгрөгөөр буурсан нь Болорхон цэцэрлэгт барилгыг шилжүүлсэн нь гол нөлөөлөл үзүүлсэн байна.
- Засгийн газрын хувь: 1,013,142.1 мянган төгрөгөөр цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант үед Иргэдийн хурлын тогтоолоор 1,084,831.9 мянган төгрөгийн хөрөнгийг Болорхон цэцэрлэгт шилжүүлсэн нь нөлөөлөл үзүүлсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 617,700.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 617,700.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 14 албан тоотоор дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 10,833.1 мянган төгрөгөөр бууруулж, 606,866.9 мянган төгрөгөөр баталсан байгаа нь шалгагдагч байгууллагын хүргүүлсэн саналын үндэслэлийг харгалзан батлагдаагүйгээс шалтгаалсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн мэргэжлийн боловсролын 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 606,866.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 489,255.6 мянган төгрөг санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 512,670.4 мянган төгрөг буюу 87.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны нэмэгдэл цалин, нормативд зардал, бусад урсгал шилжүүлэг бусад зардлуудаас 68,114.0 мянган төгрөг хэмнэсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Сургуулийн өмнөх боловсрол-71801 | 606,866.9 | 512,670.4 | 68,114.0 | 84.5 |
| 1.1 | Эрүүл мэндийг дэмжих-80605 | 1,732.4 | 1,732.0 | 0.4 | 99.9 |
| 1.2 | Тогтмол зардлыг санхүүжүүлэх-80111 | 49,497.3 | 46,454.8 | 3,402.5 | 93.9 |
| 1.3 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол-81807 | 76,561.3 | 67,754.9 | 3,490.2 | 88.5 |
| 1.4 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин-81816 | 4,591.2 | 4,591.2 | | 100 |
| 1.5 | Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх-81823 | 1,732.4 | 1,732.4 | | 100 |
| 1.6 | Явуулын багшийн үйлчилгээ-81832 | 15,286.6 | 13,809.2 | 1,477.4 | 90.3 |
| 1.7 | Боловсролын стандарт, сургалт-81834 | 351,644.8 | 310,577.2 | 41,067.6 | 85.9 |
| 1.8 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа-81835 | 105,820.9 | 89,058.7 | 4,109.9 | 84.2 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төв аймгийн Эрдэнэсант сумын хүүхдийн цэцэрлэгийн хэрэгжиж буй төсөл хөтөлбөр 84,5 хувиар хэрэгжсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Төв аймгийн Эрдэнэсант сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ын аудитор Б.Дашням, шинжээч Д.Энх-амгалан, Ө.Бат-оюун нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Эрдэнэсант сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 тоот дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт орлогын 1,899,012.6 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 28,485.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 21,363.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх, төвийн захирал албан томилолтоор ажилласан зардлаа авахгүй байх зэргээр зардлыг хэмнэх арга хэмжээг авч ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлэх 159 мэдээллээс 116 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцорсон 15 мэдээлэл, мэдээлэлгүй 17 мэдээлэл байршуулаагүй, шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагыг өссөн дүнгээр оруулаагүй байна. Шилэн дансанд 113,871.6 мянган төгрөгийн мэдээлэл байршуулахаас 48,068.2 мянган төгрөгийн мэдээлэл байршуулж 65,803.4 мянган төгрөгийн мэдээлэл дутуу байршуулсан байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалт, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалттай нийцээгүй.

*Шийдвэрлэсэн нь:* МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх , төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

4.4.2.1 Улсын бүртгэлийн гэрчилгээнд хөрөнгийн хэмжээ 27,108.4 мян төгрөг, санхүү байдлын тайлан дээр төрийн өмч 177,577.2 мянган төгрөг, Засгийн газрын оролцоо 150,468.8 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4-д үнэн зөв байх; гэсэнтэй нийцээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Мэдээллийн алдааг үнэн зөв бүртгэх зөвлөмж өгөв.

4.4.2.2 Мөнгөн хөрөнгийн түүвэрээр үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны Цахим баримтын бүрдэлд 17,146.6 мянган төгрөгийн баримт илүү бүртгэгдсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийг хөтлөхдөө нотлогдох баримтаар гүйлгээ хийх, холбогдох хууль, дүрэм журам, стандартын шалгуурт нийцсэн байх, зүй зохистой иж бүрэн байх гэсэнтэй нийцээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллах.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Засварын аудитаар 6 алдаа зөрчил илрүүлэн танилцуулсан боловч, алдаа зөрчлийг арилгах арга хэмжээ аваагүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар санхүүгийн тайланд илрүүлсэн 21,778.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгснийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | 21,778.4 | 1 | 21,778.4 | 87,3 |
| **Нийт дүн** | **1** | **21,778.4** | **1** | **21,778.4** | **87,3** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд нийт хувьсах зардлын 2 хувь хүртэл хэмжээний зардлыг зарцуулна гэснийг үзэх,
2. Боловсролын шинэчлэлтийн хуулиар олгогдсон бусад эрх хэмжээний асуудлыг үзэх

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт  мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс, дахин давтахгүй байх 1 албан шаардлага хүргүүлж, 6,996.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүллээ.

### 5.2 Албан шаардлага

5.2.1 Аудитад үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, үр дүнгийн хэрэгжилтийн талаар тайлан, санхүүгийн тодруулга тайлан ирүүлээгүй байгаа нь төсвийн захирагч эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, сум орон нутгийн боловсролын сургалтын байгууллагыг захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангаж, хууль тогтоомж, захиргааны шийдвэрийг хэрэгжүүлж, хугацаанд нь тайлагнах, удирдах ажилтны ёс зүй, манлайлал шуурхай байдлыг эрхэмлэн ажиллах гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх , төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй"; 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой

*1.1 Илрүүлэлт*: Мөнгөн хөрөнгөөр үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны Цахим баримтын бүрдэлд 6,996.1 мянган төгрөгийн гүйлгээ дутуу бүртгэгдсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийг хөтлөхдөө нотлогдох баримтаар гүйлгээ хийх, холбогдох хууль, дүрэм журам, стандартын шалгуурт нийцсэн байх, зүй зохистой иж бүрэн байх гэсэнтэй нийцээгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Цахим баримтын бүрдэлгүй гүйлгээ гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 11-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бараа материал худалдан авах анхан шатны баримт дутуу бүртгэгдсэн.. | 1 | 6,996.1 | | | | | 1 | 6,996.1 | | | | |
| Бичиг хэрэг хөтлөлт зохион байгуулалт,эмх цэгцгүй | 1 | | | | 1 | | | | | | | |
| Дүн | 2 | | | | 1 | | 1 | 6,996.1 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 159 мэдээллээс 116мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцорсон 15 мэдээлэл байршуулсан, 17 мэдээлэл байршуулаагүй байна. Шилэн дансанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний мэдээллийг мэдээлээгүй | 1 | 65,803.4 | | | 1 | 65,803.4 | | |
| | 1 | 65,803.4 | | | 1 | 65,803.4 | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Улсын хөрөнгийн засгийн газрын оролцоо зөрүүтэй байна | 1 | 150,468.8 | | | | | 1 | 150,468.8 |
| Цахим баримтын бүрдэлд 17,146.6 мянган төгрөгийн баримт илүү бүртгэгдсэн | 1 | 17,146.6 | | | | | 1 | 17,146.6 |
| Дүн | 2 | 167,615.4 | | | | | 1 | 167,615.4 |
| Нийт дүн | 3 | 233,418.8 | | | 1 | 68,805.3 | 2 | 167,615.4 |

**ТӨВ АЙМАГ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 03 сарын 12 өдөр  Дугаар 48-14510516-ТӨА-2024/263/НА-ЕТА-ТШ  Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэсант сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 65,803,400 /жаран таван сая найман зуун гурван мянга дөрвөн зуун/ төгрөг өссөн дүнгээр дутуу мэдээлсэн, хугацаа хоцорсон 15 мэдээлэл, 17 мэдээлэл байршуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн  4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;", 6 дугаар зүйлийн 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.4."таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5."цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд ил тод, бүрэн байршуулах зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт[3] ирүүлэх;

[3]Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

01904061

2. Цаашид алдаа[2], зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэсант сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Ц.Цэвээнсүрэн, нягтлан бодогч Н.Сумъяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /С.ОЮУНГЭРЭЛ/

[2]Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582